



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/213

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2017 оны А/191 А/64 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 5.2, 5.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Нянгийн эсрэг эмийн хэрэглээг тодорхойлох” ажлын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хоёрдугаар хавсралтад дурдагдсан зардлыг төсвийн хичээл, үйлдвэрлэлийн дадлага ангилалаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Б. НАРАНТУЯА

Ерөнхий захирлын 2017 оны 11 сарын
29... өдрийн 2 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

НЯНГИЙН ЭСРЭГ ЭМИЙН ХЭРЭГЛЭЭГ ТОДОРХОЙЛОХ АЖЛЫН УДИРДАМЖ

Үндэслэл

2015 оны 5 дугаар сард зохион байгуулагдсан Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагын 68-р чуулганаас гишүүн орнууд нянгийн тэсвэржилтийн эсрэг дэлхийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан гаргаж хэрэгжүүлэх, мөрдүүлэх үйл ажиллагааг улс болгон өөрийн онцлог, тэргүүлэх чиглэлд тохируулан ажиллах шийдвэр гаргасан.

Дээрх ажлын хүрээнд манай улсын Эрүүл мэндийн сайд, Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан А/191, А/64 дугаар тушаалаар “Нянгийн тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын хамтын ажиллагааны төлөвлөгөө 2017 - 2020” 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан ба төлөвлөгөөний 5.2-т “Хүний болон малын эмнэлгийн нянгийн эсрэг эмийн хэрэглээг судлах аргачлал боловсруулах”, 5.3-д “Хүн болон малын эмнэлгийн салбар дахь нянгийн эсрэг эмийн хэрэглээний судалгаа хийх”-ээр тус тус заасан.

Зорилго

Нянгийн эсрэг эмийн хэрэглээг улсын хэмжээнд тооцон гаргаж, Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагад хүргүүлэх, “Эмнэлэгт нянгийн эсрэг эмийн хэрэглээг оновчтой төлөвшүүлэх” гарын авлагаар эрүүл мэндийн байгууллагуудыг хангах.

Зорилт

Дээрх зорилгын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

1. “Эмнэлэгт нянгийн эсрэг эмийн хэрэглээг оновчтой төлөвшүүлэх ” гарын авлагын орчуулгыг хянаж, олшруулж түгээх.
2. 2015, 2016 онд эм ханган нийлүүлэх байгууллагуудаас Licemed программд ирүүлсэн импортын тайланд үндэслэн нянгийн эсрэг эмийн хэрэглээний нэгдсэн тайланг гаргаж, Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагад хүргүүлэх.
3. Тайланд тусгагдсан нянгийн эсрэг эмийг (АТС) кодлох.
4. Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг шинэчлэн, олшруулж түгээх.

Хүрэх үр дүн

1. “Эмнэлэгт нянгийн эсрэг эмийн хэрэглээг оновчтой төлөвшүүлэх ” гарын авлагатай болж, эрүүл мэндийн байгууллагууд эмчилгээнд хэрэглэсэн нянгийн эсрэг эмийн хэрэглээг тооцох нэгдсэн аргачлалтай болно.
2. Нянгийн эсрэг эмийн хэрэглээг 2015, 2016 оноор гаргасан нэгдсэн тайлан, мэдээний сантай болно.

3. Монгол улсын 2015, 2016 оны “Нянгийн эсрэг эмийн хэрэглээ”-ний тайланг Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагад хүргүүлсэн байна.

4. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд Зайлшгүй шаардлагатай эмийн шинэ жагсаалт хүргэгдсэн байна.

Санхүүжилт

Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага

Гүйцэтгэх ажлын хэсэг

Ахлагч: Г.Цэцэнсанаа /ЭМХТ-ЭЭХА-ны дарга/;


Нарийн бичиг: Ц.Болортуяа /ЭМХТ-ЭЭХА-ны мэргэжилтэн/;

Гишүүд: Ч.Амаржаргал /ЭМЯ-ны мэргэжилтэн/;
Д.Бямбадорж /ЭМХТ-ЭЭХА-ны мэргэжилтэн/;
Д.Гэрэлтуяа /АШУИС-ын багш/;
Ш.Гансаруул /УХТЭ-ийн эм зүйч/;
Ж.Жавхлан /ХСҮТ-ийн эм зүйч/.

Хугацаа

2017 оны 11 сарын 17 - 2017 оны 12 сарын 17

Хянасан:




Г.Цэцэнсанаа /ЭМХТ-ЭЭХА-ны дарга/

Боловсруулсан:



Ц.Болортуяа /ЭМХТ-ЭЭХА-ны мэргэжилтэн/

Ерөнхий захирлын 2017 оны 11 сарын
29 өдрийн 17 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



**НЯНГИЙН ЭСРЭГ ЭМИЙН ХЭРЭГЛЭЭГ
ТОДОРХОЙЛОХ АЖЛЫН ТӨСӨВ**

№	Үйл ажиллагаа	Нэгж үнэ /₮/	Тоо хэмжээ /ш/	Нийт үнэ /₮/
1	“Эмнэлэгт нянгийн эсрэг эмийн хэрэглээг оновчтой төлөвшүүлэх” гарын авлагыг хянах.	1000	50	500,000
2	“Эмнэлэгт нянгийн эсрэг эмийн хэрэглээг оновчтой төлөвшүүлэх” гарын авлага олшруулах.	2000	50	1,000,000
3	Зайлшгүй шаардалагатай эмийн жагсаалтыг шинэчлэн, олшруулж түгээх.	2000	1000	2,000,000
4	Ажлын хэсгийн гишүүдийн ажлын хөлс /тайланг боловсруулах, АТС код олгох, орчуулах, тайланг нэтгэх/.	200,000	6	1,200,000
5	Тайлан хянах (орчуулга)	-	-	300,000
6	Ажлын хэсгийн уулзалт, тайланг эцэслэх хэлэлцүүлэг.	-	-	1,000,000
	Нийт дүн			6,000,000

Хянасан:

Г.Цэцэнсанаа /ЭМХТ-ЭЭХА-ны дарга/

Д.Гантуяа /Ахлах нягтлан бодогч/

Боловсруулсан:

Ц.Болортуяа /ЭМХТ-ЭЭХА-ны мэргэжилтэн/